



МОНГОЛ УЛСЫН
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН
ГИШҮҮНИЙ ЗӨВЛӨМЖ

2022 оны 03 дугаар сарын 30

№ 03/09

Улаанбаатар хот

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА ТАНАА

Комисст хандаж ирүүлсэн гомдлын мөрөөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10, 25 дугаар зүйлийн 25.1.6, 29 дүгээр зүйлийн 29.6.4 дэх заалтад заасныг тус тус үндэслэн аймгийн сум дахь Төрийн үйлчилгээний албаны ажилчдын хөдөлмөрлөх эрх, хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн.

Комисс хяналт шалгалтын хүрээнд гомдол гаргагч болон холбогдох албан тушаалтан, ажилтнуудаас тайлбар, тодруулга, санал асуулга авах, баримт материал гаргуулан авах зэргээр холбогдох ажиллагаа явуулахад дараах нөхцөл байдал тогтоогдож байна. Үүнд:

1. Баримт материалд дүн шинжилгээ хийхэд аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/1273 дугаар захирамжаар Даланзадгад сум дахь Төрийн үйлчилгээний албаны бүтэц орон тоог 13 хүний орон тоотойгоор шинэчлэн баталсан байх бөгөөд дарга тушаалаар 2021 онд нийт 10 албан хаагчийг өөрийн санаачилгаар болон захиргааны санаачилгаар ажлаас чөлөөлсөн байна. Тус байгууллагын албан хаагчдын тогтвор, суурьшилгүй энэхүү байдал нь Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчмаас гадна мөн хуулийн 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.6, 7.1.7-д заасан төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх, улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх, төрийн алба хаах адил тэгш боломжоор хангагдах, төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлах, ил тод байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зэрэг зарчмуудыг баримтлаагүй гэж үзэх үндэслэлтэй байна.

2. аймгийн Төрийн үйлчилгээний албаны даргын 2018 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/4 дүгээр тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журамд дүн шинжилгээ хийхэд ажлын байрны дарамт, бэлгийн дарамт, аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг хориглохоор тусгасан байх боловч хүчирхийлэл түүний дотор ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, тухайн зөрчил илэрсэн тохиолдолд хүсэлт, гомдлыг хэрхэн шийдвэрлэх талаар гол зохицуулалтуудыг тусгаагүй байна. Энэ нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4.1 дэх заалтад заасан “Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан

гомдлыг шийдвэрлэх журмыг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах" гэх заалтын хэрэгжилтийг хангаагүй байна.

3. Хяналт шалгалтын хүрээнд тус албаны ажилтнуудтай хийсэн ганцаарчилсан ярилцлагаар "Манай албаны дарга ер нь харьцааны бага зэрэг асуудалтай, хүнийг хөрөнгө чинээгээр нь ялгаж харьцдаг, хүний эрхийг зөрчдөг гэж ойлгодог. ажиллах нөхцөл боломжгүй болгосон гэж боддог. Хүнийг байнга доромжлоод, гоочлоод байхаар ажиллах ямар ч урам зориггүй болж, улмаар сайн ажилласангүй гэж халдаг. Илүү цагаар ажиллуулсан цалин хөлс огт өгдөггүй, амралтын өдөр болон ээлжийн амралтаа аваад амарч байх хооронд дуудаж ажиллуулдаг" гэж тус тус тайлбар өгсөн байх бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн арван дөрөв дүгээр зүйлийн 2-т "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна", Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4 дэх заалтад "албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн бусдыг аливаа хэлбэрээр хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгах, түүнчлэн дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт үзүүлэхийг хориглоно" гэж тус тус заасныг зөрчсөн байж болзошгүй байна.

4. Гомдол гаргагчаас Комисст өгсөн нэмэлт тайлбартаа "... нь аймгийн Төрийн үйлчилгээний албаны даргаар томилогдсон цагаас эхлэн ажилчдыг ялгаварлан гадуурхах, үндэслэлгүйгээр цалин хөлс, албан тушаал бууруулах, ажлаас чөлөөлөх, халах, бүдүүлгээр дайрч доромжлох, эдийн хохирол учруулах зэргээр удаан хугацаагаар ажлын байрны болон сэтгэл зүйн дарамтад ажиллуулж байна. Ажлаас гарах хүртэл хүнд байдалд оруулж ирсэн. Би чамайг ажилд авсан учир бүх зүйлийг миний хүссэнээр хийх ёстой, ингэж чадахгүй бол ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө бичиж өг гэж дарамталж хийсэн ажил бүрийг нь үгүйсгэж шүүмжилж байсан. нь тус төвийн албан хаагчид болон үйлчлүүлж буй иргэдийн дэргэд удаа дараа чангаар шүүмжлэн доромжилж, бөө гэдгээрээ түрий барин дарамталдаг. Тэгсээр байгаад 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр намайг үндэслэлгүйгээр халсан" гэжээ.

Дээрхээс үзэхэд аймгийн Төрийн үйлчилгээний албаны дарга нь ажилтнууддаа ажлын байрны дарамт үзүүлдэг байж болзошгүй байна.

Иймд тус албаны албан хаагчдын Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ конвенц, дотоодын хууль тогтоомжоор баталгаажуулсан хөдөлмөрлөх, хөдөлмөрийн аятай, таатай нөхцөлөөр хангуулах, хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлан гадуурхалт, ажлын байрны дарамтаас ангид байх эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэгт заасныг үндэслэн Комиссын гишүүний дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. сум дахь Төрийн үйлчилгээний албаны дарга нь ажилтнууддаа ажлын байрны дарамт шахалт үзүүлсэн байж болзошгүй байх тул протоколоор сануулах;
2. Албан хаагч ажлын байран дээр ямар нэгэн дарамт, ялгаварлан гадуурхалтад өртөхгүй байх, улс төрийн намын нөлөөллөөс ангид байх

- орчныг бүрдүүлэх, хөдөлмөрийн харилцаанд давуу байдал тогтоох явдлыг гаргуулахгүй байх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж ажиллах талаар тодорхой арга хэмжээ авах, энэ талаар сургалт, сурталчилгааны ажлыг үе шаттай зохион байгуулах;
3. Тус газрын Хөдөлмөрийн дотоод журамд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хороотой 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдөр хамтран баталсан "Үлгэрчилсэн заавар"-ыг ашиглан ажлын байранд бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг болон ажил олгогч, ажилтны эрх үүргийг тусгаж, хуулийн заалтын хэрэгжилтийг хангуулах;
 4. Тус албаны ажилтнуудын тогтворгүй байдал, дарга болоод нэр бүхий ажилтнууд нь бие биенийхээ ажлын арга барилыг хүлээн зөвшөөрөхгүй байх хандлага нь тухайн байгууллагын зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх, албан хаагчдын өдөр тутмын ажлаа хэвийн гүйцэтгэх, ажлын гүйцэтгэл, бүтээлч ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг үүсгэж буй тул албан хаагчдыг эерэг орчинд, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх;

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт "Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй" гэж заасан.

Энэхүү зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу 30 хоногийн дотор бичгээр хариу ирүүлнэ үү.

Хувийг гомдол гаргагчид.

ГИШҮҮН  Х.МӨНХЗУЛ